



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ҮНДЭСНИЙ ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2025 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт, 46.2 дах хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 50.1.1, 50.4, 50.5 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дах заалт, Сангийн сайдын 2023 оны 248, 254 дүгээр журам, "Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн хөдөлмөрийн дотоод журам"-ын 2.2 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн зардлын төсвөөр бараа, үйлчилгээ худалдан авах "Үнэлгээний хороо"-ний бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Тендерийн баримт бичгийг холбогдох журмын дагуу боловсруулах, нийлүүлэгч сонгон шалгаруулах ажиллагааг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах" тухай хуулийн хүрээнд "Химийн бодис, химийн стандарт бодис"- г худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Бямбасүрэн)-д даалгасугай.

3. Үнэлгээний хорооны ажлын хэсгийн үйл ажиллагааг тайлагнахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлэн Бичиг хэрэг, архивын ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Гантуяа)-д үүрэг болгосугай.

4. Үнэлгээний хороонд ажилласан хөндлөнгийн гишүүдэд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу урамшуулал олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Х.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, техник хангамжийн хэлтэс (А.Лхамсүрэн)-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



СХЗГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний
Лавлагаа лабораторийн Ерөнхий захирлын
2025 оны 07 сарын 08 өдрийн
А/О тоот тушаалын 3 хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга: Б.Бямбасүрэн (МБЛ-ийн ахлах шинжээч)

Нарийн бичгийн дарга : Б.Гантуяа (ТУҮХЦЛ-ийн ахлах шинжээч)

Гишүүд: Б.Арвинтулга (Техникийн менежер)

Х.Ганчимэг- Зөвшилцсөнөөр, (Улаанбаатар
цахилгаан түгээх ТӨХК нягтлан бодогч)

Б.Энхболд-Зөвшилцсөнөөр, (Эрүүл мэндийн
эдийн засаг иновацийг дэмжих
үндэсний төвийн ажилтан)